



МОНГОЛ УЛС
ХЭНГИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 06 сарын 05 өдөр

Дугаар

Р/325

Хэрлэн сум

Бог малын мялзан өвчнөөс
урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын
ажлыг зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 9.4, 9.5, 9.6, 9.7, 9.8, 9.9 дэх заалт, Мал эмнэлгийн Ерөнхий газрын даргын 2023 оны А/87 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Баянмөнх, Мөрөн, Дархан суманд бүртгэгдсэн бог малын мялзан өвчний голомт, сэжигтэй бүсийн том мал болон 2023 онд шинээр гарсан аймгийн хэмжээний мэдрэмтгий бүх төл малыг уг өвчнөөс урьдчилан сэргийлж дархлаажуулах ажлыг 2023 оны 6 дугаар сарын 02-ны өдрөөс 25 хоногт багтаан шуурхай зохион байгуулсугай.


2.Урьдчилан сэргийлэх дархлаажуулалтыг Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын баталсан удирдамжийн хүрээнд технологит хугацаанд нь гүйцэтгэх, уг ажлын чанар, явц, гүйцэтгэлд хөндлөнгийн хяналт тавьж ажиллах аймгийн Онцгой комиссын гишүүдийн хуваарийг хавсралтаар баталсугай.

3.Малчдад урьдчилан мэдэгдэж тарилгын хашаа, хоолойг бэлтгүүлэх, урьдчилан сэргийлэх тарилгад ажиллах хүн хүч, машин техник, шатах тослох материалын бэлэн байдлыг ханган, багийн Засаг дарга нарыг үүрэгжүүлж ажиллахыг сумын Засаг дарга нарт даалгасугай.


4.Урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад графикт хугацаанд мал сүргээ бүрэн хамруулаагүй, хамруулахаас зайлсхийсэн малчид, мал бүхий иргэд, заавар, журмыг баримтлаагүйн улмаас малын өвчин гарах нөхцлийг бүрдүүлсэн албан тушаалтанд хуулийн дагуу хариуцлага тооцож ажиллахыг Мал эмнэлгийн газрын хяналтын улсын байцаагч нарт үүрэг болгосугай.

5.Дархлаажуулалтад шаардлагатай вакцин, мэргэжил арга зүйн заавар зөвлөмжөөр хангах, гүйцэтгэлийг хянаж шалгах, үр дүнг танилцуулахыг Мал эмнэлгийн газар (Н.Анхбаяр)-т, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Л.Батсайхан)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ



Аймгийн Засаг даргын 2023
оны 05 дугаар сарын 05-ны
дугаар захирамжийн нэгдүгээр хавсралт

Малын гоц халдварт бог малын мялзан өвчний дархлаажуулалтын ажилд
хяналт тавьж, хариуцан ажиллах онцгой комиссын гишүүдийн хуваарь

Д/д	Сумын нэр	Хяналт тавьж ажиллах Онцгой комиссын гишүүдийн овог нэр	Албан тушаал	Засаг дарга
1	Галшар	Б.Дархантөр	Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга	Д.Нямбаатар Утас:99567878
2	Баянхутаг	Ч.Баярцолмон	Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч	Б.Амгаланбат Утас: 98636699
3	Баянмөнх	О.Баяр-лхагва	Тагнуулын хэлтсийн дарга	Б.Золжаргал Утас: 99278000
4	Дархан	Б.Сүнгээ	Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга	Ж.Энхтөр Утас: 98091117
5	Дэлгэрхаан	Ж.Гантулга	Засаг даргын Тамгын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч	Э.Төгөлдөр Утас: 98632196
6	Жаргалтхаан	Ж.Эрдэнэбат	Онцгой байдлын газрын дарга	Л.Цэнгэл Утас: 92113175
7	Цэнхэрмандал	Э.Мөнх-Эрдэнэл	Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга	С.Золжаргал Утас: 97186060
8	Өмнөдэлгэр	Б.Дарханбаатар	Хууль зүйн хэлтсийн дарга	Б.Эрдэнэбаатар Утас: 88092147
9	Батширээт	Н.Хүрэлээ	Цэргийн штабын дарга	Г.Гансүх Утас: 86067052
10	Биндэр	Л.Мэндбаяр	Эрүүл мэндийн газрын дарга	Э.Мөнх-Очир Утас: 97031765
11	Баян-Адарга	Н.Анхбаяр	Мал эмнэлгийн газрын дарга	О.Лхагвадорж Утас: 98819081
12	Дадал	Д.Өнөрцэцэг	Нийгмийн бодлогын хэлтсийн дарга	Д.Мөнх-Од Утас: 93014267
13	Норовлин	Ч.Гантогтох	Онцгой байдлын газрын хошууч	А.Мөнхбайгаль Утас: 99665599
14	Батноров	Л.Өлзийбат	Улаан загалмайн хорооны дарга	Б.Жавхланбаяр Утас: 91114371
15	Баян-Овоо	Х.Уртнасан	Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын дарга	Д.Баянмөнх Утас: 93191029
16	Мөрөн	С.Нямдаваа	Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга	Ц.Батцоож Утас: 98022002
17	Хэрлэн	М.Шүрэнцэцэг	Хэрлэн сумын Засаг дарга	М.Шүрэнцэцэг Утас:92113141
18	Бор-Өндөр	Д.Батхүү	Цагдаагийн газрын дарга	Г.Адъяабилэгт Утас: 88887811